

Анги:  
Овог..... Нэр.....  
Хугацаа: 50 мин

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН “ХИМИ” СОНГОСОН  
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

**А хувилбар**  
**СОНГОХ ДААЛГАВАР**

1. Химийн бодисыг бүрдүүлэгч цаашид үл хуваагдах, хамгийн жижиг хэсгийг  
.....гэнэ /1 оноо/.

- A. Молекул
- B. Атом
- C. Ион
- D. Элемент

2. Агаарын бөмбөлгийг хийлэх үед...../2 оноо/

- A. Тэлж үлээхийн хэрээр бөмбөлөг доторх даралт агаарын даралтаас их болно.
- B. Тэлж үлээхийн хэрээр бөмбөлөг доторх даралт агаарын даралтаас бага болно.
- C. Бөмбөлөг дотор тэлэлт явагдана.
- D. Дээрх бүгд зөв

3. Дараах хүснэгтийг гүйцээнэ үү? /1 оноо/

№	Химийн тэмдэг	Монгол нэр	Дуудлага
1		Устөрөгч	
2	Ar		
3			Эс

4. Химийн нэгдэл болох хүнсний содын шинж чанарын өгүүлбэрийг гүйцээж бичнэ  
үү?/1оноо/

- A. Хүнсний сод нь .....өнгөтэй.....бодис юм.
- A. Цагаан, талст      B. Цагаан, хатуу      C. Саарал, уусдаг      D. Талст, цагаан

5. Металл бишийн металлаас ялгарах онцлог шинж аль нь вэ?/1оноо/

- A. Зарим нь тасалгааны температурт шингэн хий
- B. Хэврэг, хялбар бутарна
- C. Бат, бэх
- D. Зөвхөн хатуу төлөвт

6. Химийн нэгдэл өөр бодистой харилцан үйлчлэх шинжийг .....гэнэ./2оноо/

- A. Физик шинж чанар      B. Хими шинж чанар      C. Холимог      D. Элемент

7. Химийн элемент, ..... нь урвалд орж, шинэ химийн ..... үүсгэнэ.

- A. Элемент      B. Нэгдэл      C. Холимог      D. Ус

8. Дараах үзэгдлүүдээс физикийн ба химийн үзэгдлийг ялгаж бичнэ үү?/2оноо/

**бялуу хийх, сүү хөлдөх, өндөг чанах, цаас урах**

Физикийн үзэгдэл	Химийн үзэгдэл

9. Үгэн тэгшитгэлийг гүйцээж бичнэ үү./2оноо/

- 🧪 Кальци+ хүхэр →

- Лити + хүхэр →
- Магни+хлор=
- Натри + хүчилтөрөгч →

10. Хүн төрөлхтөн хийг хураан авч өргөн хэрэглэдэг. Хураан авч шахсан хийнүүдийн хэрэглээг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /2 оноо/

Шахсан хий

Хэрэглээ

1. Азот

W. Баярын чимэглэл

2. Гели

X. Амьсгалын аппарат

3. Нүүрсхүчлийн хий

Y. Галын хор

4. Хүчилтөрөгч

Z. Автомашины дугуй

A. 1Z,2X,3Y,4W

B. 1Y 2W 3Z 4X

C. 1Z 2W 3Y 4X

D. 1Y 2Z 3X 4W

11. Хоосон зайг нөхнө үү?/2 оноо/

Индикатор	Индикаторын уусмалын өнгө	Саармаг уусмал	Хүчлийн уусмал	Суурийн уусмал
Метилоранж				

12. Төмрөөс гадна бусад металл тодорхой нөхцөлд идэгдэж мууддаг. Тэрхүү бусад металлын идэгдэх үзэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?/1 оноо/

A. Корроз

B. Практикийн ач холбогдолгүй химийн урвал

C. Нэгдэх урвал

D. Төмөр шатах

13. Дараах химийн тэмдэглэгээнүүдээс “идэмхий” гэсэн тэмдэглэгээг олно уу? /2 оноо/



A.

B.

C.

D.

14. Хүчиллэг бороо барилга болон хөшөө дурсгалд хэрхэн нөлөөлөх вэ?/2оноо/

A. Шохойгоор хийдэг тул хүчиллэг бороонд амархан уусч эвдэрнэ

B. Шохойгоор хийдэг тул хүчиллэг бороонд эвдрэхгүй

C. Цементээр хийдэг тул хүчиллэг бороонд ямар нэгэн өөрчлөлт орохгүй

D. Цемент, шохойгоор хийдэг тул хүчиллэг бороонд ямар нэгэн өөрчлөлт орохгүй

15. Судлаачдын туршилтаар өөрчилж буй тоо хэмжээг юу гэж нэрлэдэг вэ?/1 оноо/

A. Хувьсагч

B. Үл хамаарах хувьсагч

C. Хамаарах хувьсагч

D. Тогмтол

16. Хөрсний найрлагыг бүрдүүлэгч дараах бүрэлдэхүүн хэсгүүдээс аль хамгийн их хувийг эзлэх вэ? /1 оноо/

A. Ус

B. Эрдэс бодис

C. Агаар

D. Органик бодис

17. Сурагч гэртээ алимны мод тарихаар төлөвлөсөн бол дараах хөрснүүдээс алийг нь сонговол ургалт сайн байх вэ?

A. Саармаг орчинтой хөрс

B. Хүчиллэг орчинтой хөрс

C. Суурилаг орчинтой хөрс

D. Чийглэг агаарын хэмжээ багатай хөрс

18. Ус хог хаягдал болон химийн бодисоор бохирдож, шинж чанар нь өөрчлөгдөхийг юу гэж нэрлэдэг вэ? /1оноо/

- A. Усны химийн найрлага
- B. Усны бохирдол
- C. Бохирдуулагч хүчин зүйл
- D. Өөрчлөлт

19. Хүний үйл ажиллагааны улмаас янз бүрийн химийн бодис, ахуйн болон үйлдвэрийн хаягдал хөрсөнд шингэж ургамаль амьд организмд сөрөг нөлөө үзүүлэх, хуримтлагдах үзэгдлийг .....гэнэ. /2оноо/

- A. Хөрсний ялзрал
- B. Хөрсний бохирдол
- C. Цөлжилт
- D. Хөрсний даац хэтрэх

### ЗАДГАЙ ДААЛГАВАР

1. Металл ба металл бишийн физик шинжийн ялгааг гаргаж хүснэгтийг бөглөнө үү?/3оноо/

Шинж чанар	Металл	Металл биш
Төлөв		
Нягт	Нягт ихтэй /натри, кали, кальци, зэрэг нягт багатай цөөн металл бий/	
Хатуу чанар	Хатуу чанар сайтай/мөнгөн ус натри, кали, цагаантугалга, кальциас бусад нь/	
Давдагдах		
Уян хатан		Металл бишээр нарийхан утас хийх боломжгүй
Дулаан дамжуулах		

2. Хүснэгтэд бодисын нэр болон түүний найрлагыг харуулжээ. Аль нь химийн элемент, нэгдэл болохыг тогтоож, хүснэгтэн мэдээллийг нөхөж бичнэ үү. /3 оноо/

	Бодисын нэр	Найрлага	Элемент	Нэгдэл	Химийн тэмдэг
a	Магни	Магни			
b	Фтор	Фтор			
c	Натри	Натри			
d	Калийн оксид	Кали, хүчилтөрөгч			
e	Зэсийн сульфид	Зэс, хүхэр			
f	Кальци	Кальци			

3. Дараах асуултуудад хариулна уу? /3оноо/

Нэгэн туршилтын явцыг үгэн тэгшитгэлээр илэрхийлжээ.

Давсны хүчил+натрийн гидроксид=давс+ус

1. Уусмалын хүчиллэг шинжийг өөрчлөхөд ямар бодис ашигласан бэ?

.....

2. Ямар урвал явагдсан бэ?

.....

3. Туршилтаас үүссэн давсыг уусмалаас ямар аргаар цэвэрлэх вэ?

.....

4. **Алт, төмөр, магни зэрэг элементүүд цахилгааныг дамжуулдаг бол хүхэр, фосфор зэрэг элементүүд цахилгааныг дамжуулдаггүй.**

Дээрх мэдээллийг уншаад дараах асуултад хариулна уу. /3оноо/

а. Өгсөн элементүүдийн аль нь металл вэ? .....

б. Ямар элемент зэврэлд орох вэ? .....

с. Зэврэх үзэгдлийг үгэн тэгшитгэлээр илэрхийлнэ үү. ....

...

5. Хөрсний бохирдлоос сэргийлэх арга замуудаас нэрлэж бичнэ үү? /3 оноо/

1 .....

2 .....

3 .....

Анги:  
Овог..... Нэр.....  
Хугацаа: 50 мин

2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН 7 ДУГААР АНГИЙН “ХИМИ” СОНГОСОН  
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

**В хувилбар**

**СОНГОХ ДААЛГАВАР**

- Хоёр ба түүнээс дээш тооны атомаас тогтсон жижиг хэсгийг.....гэнэ./1 оноо/  
А. Атом                      В. Молекул                      С. Бодис                      D. Биет
- Хийн жижиг хэсгүүд савныхаа ханыг мөргөх хүчийг юу гэж нэрлэдэг вэ?/2 оноо/  
А. Хийн даралт              В. Диффуз                      С. Уусах үзэгдэл              D. Броуны хөдөлгөөн
- Дараах хүснэгтийг нөхнө үү? /1оноо/

№	Химийн тэмдэг	Монгол нэр	Дуудлага
1		Хүчилтөрөгч	
2	Ca		
3			Пэ

- Кальцийн нягт 2 гр/см<sup>3</sup>, масс 40 гр бол нягтыг олно уу? /1 оноо/  
А. 20гр                      В. 0,5 гр                      С.10 гр                      D. 80 гр
- Дулаан сайн дамжуулдаг материалыг сонгоно уу?/1 оноо/  
А. Төмөр                      В. Мод                      С.Хуванцар                      D. Шил
- Химийн бодисыг бүрдүүлэгч цаашид үл хуваагдах хамгийн жижиг хэсгийг нэрлэнэ үү?/1оноо/  
А. Молекул                      В. Атом                      С.Ион                      D. Элемент
- Төмөр ба хүхрийг холиод шинж чанарыг нь туршихад элемент тус бүр нь өөрийн шинжээ хадгалж байна. Хэд хэдэн төрлийн химийн элемент, нэгдлээс тогтох бодисыг..... гэнэ. /2 оноо/  
А. Холимог                      В. Нэгдэл                      С. Атом                      D. Элемент
- Дараах үзэгдлүүдээс физикийн ба химийн үзэгдлийг ялгаж бичнэ үү?/2оноо/.

мөс хайлах,              мод шатах,              шоколад хайлах,              бялуу хийх

Физикийн үзэгдэл	Химийн үзэгдэл

- Үгэн тэгшитгэлийг гүйцээж бичнэ үү./2оноо/

- Кали + хлор →
- Натри + хүхэр →
- Кали + хүхэр→
- Кали+ ус→

10. Химийн урвалын үгэн тэгшитгэлийн эх бодис ба бүтээгдэхүүн бодисыг зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу? /2 оноо/

Эх бодис

Бүтээгдэхүүн бодис

1. Магни+ ус →
2. Магни+хүхрийн хүчил →
3. Магни+давсны хүчил →

- X. Магнийн хлорид+устөрөгч
- Y. Магнийн сульфат+ устөрөгч
- Z. Магнийн гидроксид+устөрөгч

A. 1X 2Y 3Z

B. 1X 2Z 3Y

C. 1Z 2Y 3X

D. 1X 2X 3Y

11. Хоосон зайг нөхнө үү?/2 оноо/

Индикатор	Индикаторын уусмалын өнгө	Саармаг уусмал	Хүчлийн уусмал	Суурийн уусмал
Фенолфталеин				

12. Төмөр зэврэх үзэгдэл шиг ахуй амьдралд сөрөг нөлөө, хохирол учруулдаг химийн хувирлыг .....гэдэг./1оноо/

- A. Практикийн ач холбогдолгүй урвал
- B. Исэлдэх урвал
- C. Нэгдэх урвал
- D. Шатах урвал

13. Аль нь зэврэлээс хамгаалах арга биш вэ?/2 оноо/

- A. Хуванцараар бүрэх
- B. Тосолгоо хийх
- C. Будгаар будах
- D. Усаар норгох

14. Шинжлэх ухаанч арга барилын 4-н үе шатыг зөв дараалалд оруулан тасархай зураасан дээр харгалзах дугаарыг бичнэ үү?/2оноо/

- A. Баримт нотолгоогоо үнэлэх 1.....
- B. Таамаглал дэвшүүлэх 2.....
- C. Шинжлэн судлах ажлыг төлөвлөх 3.....
- D. Баримт нотолгоо гаргах тайлагнах 4.....

15. Хүчиллэг борооны сөрөг нөлөөг сонгоно уу?/1оноо/

- A. Хөрсний хүчиллэг шинж ихэсч ургамлын өсөлтөнд сайнаар нөлөөлнө.
- B. Хөрсийг бордож урагмлын өсөлтөд сайнаар нөлөөлнө.
- C. Хөрсний хүчиллэг шинж ихэсч ургамлын өсөлтөд сөргөөр нөлөөлнө.

16. Хөрсний химийн найрлагыг зөв илэрхийлсэн хариултыг сонгоно уу?/1 оноо/

	Органик бодис%	Агаар %	Ус %	Эрдэс бодис%
A	25%	25%	47%	25%
B	3%	47%	25%	25%
C	47%	25%	25%	3%
D	3%	25%	25%	47%

17. Ямар орчинтой хөрс нь ургамлын өсөлтөд тохиромжтой байдаг вэ? /1 оноо/

- A. Хүчиллэг
- B. Суурилаг
- C. Саармаг

18. Голын эргийн хөрсний бүрэлдэхүүн хэсгийг аль нь хамгийн их эзлэх вэ? /1оноо/

- A. Элс
- B. Лаг шороо
- C. Шавар
- D. Аль нь ч

биш

19. Голын усанд хувцас угаах нь усны ямар бохирдлыг үүсгэх вэ? /2 оноо/



- A. Хатуу хог хаягдлын
- B. Уусдаг хаягдлын
- C. Уусдаггүй хаягдлын
- D. Түлшний

**ЗАДГАЙ ДААЛГАВАР**

1. Өгөгдлийг уншиж тийм үгүй сонгоно уу? /3 оноо/

№	Асуулт	Тийм/үгүй
1	Бүх металл хүчилтэй урвалд орох	
2	Металл, металл бишийг химийн нэгдлийг нь цахилгаанаар задалж гарган авдаг	
3	Металл биш нь зөвхөн хатуу төлөвт байдаг	
4	Мөнгөн усны уур маш хортой мэдрэлийн системийг алдагдуулдаг.	
5	Бром нь шингэн төлөвтэй	
6	Металл ба металл биш нь өөр хоорондоо хими ба физик шинжээр ялгагдана.	

2. Хүснэгтэд бодисын нэр болон түүний найрлагыг харуулжээ. Аль нь химийн элемент, нэгдэл болохыг тогтоож, хүснэгтэн мэдээллийг нөхөж бичнэ үү. /3 оноо/

	Бодисын нэр	Найрлага	Элемент	Нэгдэл	Химийн тэмдэг
a	Ус	Устөрөгч, хүчилтөрөгч			
b	Хүчилтөрөгч	Хүчилтөрөгч			
c	Натри	Натри			
d	Хүхрийн оксид	Хүхэр, хүчилтөрөгч			
e	Төмрийн сульфид	Төмөр, хүхэр			
f	Кали	Кали			

3. Дараах асуултуудад хариулна уу? /3оноо/

Гурван хуруу шилэнд үл мэдэгдэх уусмал байжээ.

- ✚ Эхний хуруу шилэнд универсаль индикаторын цаасыг дүрэхэд улаан
- ✚ хоёр дахь хуруу шилэнд ногоон
- ✚ гурав дахь хуруу шилэнд цэнхэр болж байсан бол уусмалын орчин ямар байсан бэ? Тохиолдол тус бүрт тохирох нэг бодисыг нэрлэнэ үү?

Эхний хуруу шилэн дэх уусмалыг лакмусаар туршвал ямар өнгөтэй болох вэ?

4. Зурагт үзүүлсэн шиг зуслангийн хашаа болон байгууллагын хашаа, замын хажуугийн

хашааг металаар хийсэн байдаг. Металл хашааны зарим хэсэг нь хэсэг хугацааны дараа өнгө нь өөрчлөгдөж зэвэрч эхэлсэн байдаг./3 оноо/



а. Хашааг ямар металаар хийдэг вэ? Зөв хариултыг дугуйлна уу

- a. Хөнгөнцагаан                      b. зэс                      c. төмөр                      d. хартугалга**

б. Хашааны металл хэсэг зэврэхэд нөлөөлдөг 2 бодисыг сонгож дугуйлна уу.

- Устөрөгч                      нүүрсхүчлийн хий                      хүчилтөрөгч                      азот                      ус**

с. Төмөр хашааг зэврэлээс хамгаалах аргуудаас нэгийг бичнэ үү.

.....  
5. Хөрсний бохирдлын эх үүсвэрийг нэрлэж бичнэ үү? /3 оноо/

- 1 .....  
2.....  
3.....